

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын 2018-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэх арга хэмжээний жилийн эцсийн биелэлт

2018.12.05.

Шивээговь сум

№	Зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Биелэлт	Хувь
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ								
1	Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг багасган, хэмнэлтийг эрхэмлэнэ.	1	Төсвийн сахилга бат, санхүүгийн хяналтын үр дүнг сайжруулна.	Жилдээ	Төрийн байгууллагууд хэмнэлтийг эрхэмлэн, төсвийн сахилга батыг хангаж ажилласан байна. Төсвийн шууд захирагч нарын хариуцлагыг сайжруулна.	-	Засгийн газрын 147-р тогтоолын биелэлтийг улирал бүр тайлагнан 3 дугаар улирлын байдлаар хэмнэлт-41194,6 мянган төгрөг, хэтрэлт-21801,5 мянган төгрөг бөгөөд 94,5 хувийн хэрэгжилттэй байна. Улсын их хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган санхүү, төсвийн мэдээллүүдийг шилэн данс болон мэдээллийн самбарт сар бүрийн 10-ны дотор байршуулан ажиллаж байна. Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн мэдээг санхүүгийн мэдээллийн самбарт сар бүрийн 10- ны дотор, цахим болон шилэн дансанд сар бүрийн 8-ны дотор байршуулан ажиллаж байна. Сумын бүх төсвийн байгууллагын санхүүгийн баримтанд 2 удаа хяналт хийж арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажилласан. Төсвийн байгууллагууд нийт 24327,6 мянган төгрөгийн өглөгтэй байна. Энэ нь цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор Нийгмийн даатгалд 11107,2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, цэвэр усны үнэ 4 дахин нэмэгдэж 9544,3 мянган төгрөг, суманд 1-р сард шүлхий өвчин гарсантай холбогдуулан 1550,0 мянган төгрөгийн шатхууны өглөгүүд үүссэн байна. 2017, 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжийн дагуу зөрчил дутагдал гаргасан албан хаагчид болон төсвийн шууд захирагч нарт хариуцлага ногдуулсан.	100
		2	Орон нутгийн хөгжлийн санг иргэдэд ил тод, нээлттэй болгож, зарцуулалтын үр дүнг дээшлүүлнэ.	Жилдээ	Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг иргэдээр эрэмбэлүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. Орон нутгийн хөгжлийн санг журмын дагуу зарцуулж, үр дүнг олон нийтэд тайлагнана. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн	-	2018 оны 1 дүгээр улиралд багийн Засаг дарга нар 2019 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын саналыг батлагдсан маягтын дагуу 957 өрх буюу сумын нийт өрхийн 89,6 хувиас авч саналын урьдчилсан жагсаалт бэлтгэн БИНХ-аар хэлэлцүүлэн Засаг даргын 2018 оны А47 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг хуралдаж нэгдсэн жагсаалтыг хэлэлцэн СИТХ-д хүргүүлсэн. ОНХС-ийн хөрөнгө зарцуулалтын мэдээг сар бүр шилэн данс, цахим худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn сайт, сумын албан ёсны цахим хуудасд тухай бүр байршуулж, ЗДТГ-ын хөрөнгө оруулалтын мэдээллийн самбаруудад байршуулан иргэдэд ил тод мэдээлэн ажилласан. Мөн 1, 2 багийн иргэдийн нийтийн хурлаар иргэдэд 2017 оны орон нутгийн хөгжлийн сангийн 171 270 999 төгрөгийн хөрөнгөөр хийгдсэн 16 ажлын тайлан болон 2018 онд 173,177,800 төгрөгийн хөрөнгөөр	100

					үр дүнд бий болсон эд хөрөнгийг эзэнжүүлж, ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.		хийж гүйцэтгэж байгаа 21 ажлын танилцуулгыг хүргэн ажилласан. 2017 оны ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 10 хөрөнгийг холбогдох байгууллагуудын үндсэн болон эргэлтийн хөрөнгөнд авч бүртгэлжүүлсэн.	
2	Бизнесийн таатай орчин бүрдүүлж, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.	3	Тусгай зөвшөөрлийг хуулийн хүрээнд хүнд сурталгүй олгож, хяналт шалгалтын давхардлыг багасгана.	Жилдээ	Хуулийн хүрээнд шаардлага хангасан аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрлийг олгоно. Хяналт шалгалтыг цөөрүүлж, зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлнэ.	-	2018 онд тамхины тусгай зөвшөөрөлийн хугацаа нь дууссан 1 ААН, архины тусгай зөвшөөрөлийн хугацаа нь дууссан 3 аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлийг сунгуулан хяналт тавин ажиллаж байна. ААН болон худалдаа үйлчилгээ эрхлэж байгаа иргэдийн үйл ажиллагаанд 3 удаа аймгийн мэргэжлийн хяналтын газар, ХХААГ-тай хамтран хяналт тавьж, үр дүнг танилцуулан ажилласан. Мөн суманд үйл ажиллагаа явуулдаг тамхины тусгай зөвшөөрөлтэй 2 ААН, 4 иргэн, архины тусгай зөвшөөрөлтэй 8 аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд цагдаагийн хэсэгтэй хамтран улирал бүр хяналт тавин ажиллаж байна.	100
		4	ЖДҮДС, СХС-ийн зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	Жилдээ	Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд олгох зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. ЖДҮДС, СХС-ийн зээлийн эргэн төлөлт, ашиглалтыг сайжруулна. Бий болсон байнгын ажлын байрны тоо - 25 Хуваарийн дагуу эргэн төлөлт – 100 хувь	СЗДТГ, ЖДҮД С СХС	2018 онд СХС, ЖДҮДС-аас зээл авсан иргэн байхгүй болно. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг Сумын ИТХ-ын 2018 оны 05 сарын 30-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон. Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийг нэмэгдүүлэх зорилгоор 2011-2016 онуудад зээл авсан 30 иргэнд зээлийн эргэн төлөлтийг барагдуулах тухай СЗД-ын албан бичиг хүргүүлж 10 иргэнийг шүүхэд өгч 2018 ондоо төлбөрөө төлж барагдуулахаар тохиролцсон. 2011-2016 онд нийт 60 иргэн 332.800.000 төгрөгийн зээл авч 94 ажлын байр бий болгосноос 2018 оны байдлаар 237.982.710 төгрөг эргэн төлөгдөж 40 ажлын байр хадгалагдан үлдсэн байна. 2018 онд нийт 63128000 төгрөгийн эргэн төлөлт төлхөөс 11 дүгээр сарын байдлаар 50.678.343 төгрөг төлөгдөж, эргэн төлөлт 80,2%-тай байна.	70
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ								
2.1 Худалдаа, үйлчилгээний салбар								
Худалдаа үйлчилгээний чиглэлээр								
3	Худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн өрсөл дөх чадварыг дээшлүүлнэ.	5	Орон нутгийн худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.	Жилдээ	Худалдаа, үйлчилгээний байгууллагуудын мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж соёл, стандартыг дээшлүүлэх сургалт явуулах, зөвлөгөөн зохион байгуулах, тусгай зөвшөөрөл тохирлын гэрчилгээтэй болгоно.	Хөтөлбөр	Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчилах зорилгоор сумын “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдааг 2018 оны 09-р сард зохион байгуулж 13 иргэн 6 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнээр оролцож төрөл тус бүрийн ялагчийг тодруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Мөн аймгийн үзэсгэлэн худалдаанд 4 иргэн 3 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр амжилттай оролцсон. Монголын Үндэсний арьс ширний нэгдсэн холбоотой хамтран 2018 оны 10 дугаар сард “Мах, малын арьс ширийг механик гэмтэлгүй хэрхэн зөв, анхан шатны боловсруулалтыг хийх, бэлтгэх, хадгалах, хамгаалах” тэдгээрийн ашиглалтыг сайжруулах орлогоо нэмэгдүүлэх	70

							чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтанд сумын түүхий эд бэлтгэгч 2 иргэн, 4 малчинг хамруулсан. Мөн Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, хоршоодын төлөөлөл болох 5 иргэнийг Улаанбаатар, Сэлэнгэ, Өмнөговь, Дорнод зэрэг газруудад зохион байгуулагдсан сургалт, зөвлөгөөнд хамруулсан. Аймгийн бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдийн дунд зарлагдаж байгаа “Нэг суурин-Нэг бахархал” аяны нээлтэнд 15 иргэнийг хамруулсан. Аймгийн хэмжээнд 12-р сарын 14-нд зохион байгуулагдах “Бизнес эрхлэгчид”-ийн зөвлөгөөнд 30 бизнес эрхлэгчдийг хамруулахаар бэлтгээд байна.	
2.2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн салбар								
Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр								
4	Хүнсний үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний аюулгүй байдлыг хангана.	6	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр, цех байгуулах үүсгэл санаачлагыг бодлогоор дэмжинэ.	Жилдээ	Мах, сүү боловсруулах үйлдвэр, цехийн үйл ажиллагааг өргөжүүлсэн байна.	СХС 15.0	Суманд мах сүү боловсруулдаг цех үйлдвэр байдаггүй. Хэрчсэн гурилын “Оргил” цех шинээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж ажилгүй 2 иргэнийг байнгын ажлын байраар хангаад байна.	100
		7	Стандартын шаардлага хангасан зоорь, агуулахын тоог нэмэгдүүлнэ.	Жилдээ	Мэргэжлийн байгууллагуудтай хамтран зоорь эзэмшигч иргэд, ААН, байгууллагуудад зоорины стандартын тухай сургалт зохион байгуулна. Зоориноос зах зээлд нийлүүлэх мах, төмсний хэмжээг нэмэгдүүлнэ. Зоорь агуулах саванд ариутгал хийлгэнэ.	СХС	Зоорь, агуулахын тооллогын ажлыг зохион байгуулж суманд төмс, хүнсний ногооны 4, махны 1, ашиглагдаггүй 1 нийт 6 зоорь байна. 2018 онд махны 1 зооринд ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэсэн. Мөн төмс, хүнсний ногооны 4, махны 1 зоориос 3 тн мах, 300 кг төмс, хүнсний ногоог зах зээлд нийлүүлж байна.	70
		8	Мал нядалгааны цех байгуулахад бодлогоор дэмжнэ.	Жилдээ	Шаардлагатай дэд бүтцийг шийдвэрлэн, цех байгуулагдсан байна.	-	1. 2014 оноос эхлэн 1-р багийн иргэн Б.Батбаяр мах бэлтгэлийн цех ажиллуулж байгаа ба тус цэгийн 1176 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн. Мал нядалгааны стандартын шаардлага хангасан 1 цэгтэй болох зорилгоор газрын байршлыг эрчимжсэн МАА-н бүсэд гаргахаар газрын асуудлыг шийдвэрлэж зориулалтын бус газар мах нядалгааны цэг ажиллуулж байгаа иргэнийг нүүлгэн шилжүүлэхийг зөвлөөд байна.	70
		9	Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээнд тавих хяналтыг сайжруулна.	Жилдээ	Тухайн жилийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 100 хувь Хүнсний бүтээгдэхүүний эрүүл аюулгүй байдлын хяналт сайжирна.		Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран хүнсний бүтээгдэхүүний шинжилгээнд тавих хяналтыг суманд хүнсний бүтээгдэхүүний үйл ажиллагаа явуулдаг 20 гаруй иргэн, ААНБ-аар 4 удаа хяналт тавьж, зөвлөгөө өгч, гарсан зөрчлийг арилгах үүрэг даалгаварыг өгч ажилласан.	100
Мал аж ахуйн чиглэлээр								
5	Бэлчээрийн мал аж ахуйг эрсдлээс	10	Мал үржлийн нэгжийг бий болгон, өндөр ашиг шимт малыг	Жилдээ	Цөм сүргийн болон бог малын нийт хээлтүүлэгч малыг ангилалт, баталгаажуулалтанд 100% хамруулж,хээлтэгч	0.8	Хувийн мал үржлийн нэгж байгуулах иргэдийг хайж зар тависан боловч хүсэлт гаргасан иргэн одоогоор байхгүй болно. Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын “Сүмбэр хишигтэн зоо” мал үржлийн нэгжтэй гэрээ байгуулан 2018	

хамгаалж, үүлдэр, угсааг сайжруулж, ашиг шимийг дээшлүүлнэ		бүртгэлжүүлж, гарал үүслийг тодорхой болгоно.		малын 10% -ийг ээмэгжүүлэн, ангилалт, баталгаажуулалт хийсэн байна.		оны технологит ажлыг хийлгэж бог малд ангилалт, баталгаажуулалт хийх, ээмэгжүүлэх ажлыг хавар, намарын улиралд зохион байгуулж нийт 3000 толгой бог малд ангилалт хийж, 600 малыг ээмэгжүүлсэн байна.	100
	11	Ямааг ноолуур, махны чиглэлээр, хонь, үхрийг махны чиглэлээр үржүүлж, ашиг шимийг дээшлүүлнэ.	Жилдээ	Бог малын хээлтүүлэгч худалдан авч малчдад гэрээгээр ашиглуулна.	ОНХС-2,0	“Малын үүлдэр угсааг сайжруулах”-аар ОНХС-ийн 2 сая төгрөгийн хөрөнгөөр махны чиглэлийн Керей үүлдэрийн 1 хуц, торгууд үүлдэрийн 1 хуц, керей үүлдэрийн 6 хурган хуц, ноолуурын чиглэлийн 4 ухна худалдан авсан. Сумын 3 малчин өрх залаа жинстийн цагаан ухнаар ямаан сүргийн үүлдэр угсааг сайжруулсан. Мөн нэг өрх Төв аймгийн Баян сумаас Алатау үүлдрийн бухыг авчирч үүлдэр сайжруулагчаар ашиглаж байна. Сумын хэмжээнд нийт 243 бог малын хээлтүүлэгчийг эх сүргээс нь ялган суурилуулахаас 113 хээлтүүлэгч буюу 46,5%-тай ялган суурилуулсан байна.	100
	12	Бэлчээр ийн менежментийг хэрэгжүүлж, ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.	Жилдээ	Шинээр гаргах инженерийн хийцтэй худаг-1 5000 га-д хортон мэрэгчидтэй тэмцэнэ. 5 га талбайд олон наст ургамал тарьж, бэлчээрийг өтгөрүүлнэ.	УТХО1 8.0 ОНХС 1.0 ОУХО	Бэлчээрийн менежментийн 2018 оны төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай хэрэгжсэн байна. Хавар, намрын бэлчээрийн даац, багтаамжийг тооцон ажиллахад хавар ургамлын гарц муу байсан учир бэлчээрийн даац 3 дахин хэтрэлттэй гарч намрын бэлчээрийн даацын мониторинг үнэлгээгээр сумын бэлчээр талхлагдлын байдал дундаж үзүүлэлттэй дунджаар 100 га талбайд 30-40 хонин толгой бэлчээрлэх боломжтой гэсэн үнэлгээтэй гарсан. Бэлчээрт тандалт судалгаа хийж сумын нутаг дэвсгэрийн оготно мэрэгч ихтэй газрын байршлыг тогтоож ОНХС-ийн 1 сая төгрөгийн хөрөнгөөр 10 цэгийн 12 га газар, Улсын төсвийн 3,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 цэгийн 2000 га газарт тус тус хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг энгийн, механик, биологийн аргаар зохион байгуулж ажилласан. Олон наст тариалах ажлыг хашсан талбайтай айл өрхүүдийн дунд өрнүүлэн 2-р багийн иргэн Ц.Нэргүй 1 га талбайд олон настын үр цацан ургуулж байна. Улсын төсвийн 18 сая төгрөгийн хөрөнгөөр сумын 2 дугаар багийн нутаг Тарвагат дулааны энгэр гэдэг газарт бэлчээрийн зориулалтаар шинээр гүний худаг гаргуулан улсын комисс хүлээн авсан. Мөн 22-р зөрлөгийн зүүн талд байрлах бэлчээрийн худаг эвдэрсэнийг малчдын хөрөнгөөр засварлан ашиглаж байна.	100
	13	Хадлангийн тоног төхөөрөмжийн хувийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах	Жилдээ	Хадлангийн тоног төхөөрөмж худалдан авах хөрөнгийг шийдвэрлүүлнэ.	-	2019 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын нэгдсэн жагсаалтад хадлангийн тоног төхөөрөмж худалдан авах саналыг тусгаад байна.	Үнэлэх боломжгүй.
	14	Малжуулах төслийг үргэлжлүүлэн	Жилдээ	Ган, зуд гамшгийн эрсдэлд өртсөн, амьжиргааны баталгаажих түвшнээс	-	“Иргэдийг малжуулах журам”-ын дагуу цөөн мал бүхий 4 малчин өрхөд тус бүр 40 хонь, 20 ямаа нийт 240 толгой малыг гэрээгээр хүлээлгэн өгч малжуулах ажлыг зохион	

			хэрэгжүүлнэ.		доогуур орлоготой малчин өрхийг малжуулна. Малчдыг сургалтанд хамруулж, туршлага судлуулж, сайн туршлагыг нэвтрүүлнэ.		байгуулсан. Мөн ХХҮГ-аас хэрэгжүүлдэг “Тэгш дүүрэн” хөтөлбөрт Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй 3 өрхийг хамруулж өрх бүрт 32 толгой ямааг хүлээлгэн өгсөн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хүрээнд “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т 2-р багийн иргэн Д.Эрдэнэхишигийн төсөл дэмжигдэж гэрээ байгуулан 4 сая төгрөгийн 40 толгой хонийг хүлээн авсан. ХААИС-ийн багш нарын зохион байгуулсан бэлчээр ашиглах олон наст ургамал тариалах сургалтанд 5 малчин, Монгол ВИ.И.ТИ.НЕТ ХХК-тэй хамтран зохион байгуулсан малын 10 төрлийн өвчнийг хэрхэн эмчлэх, ямар эмээр эмчлэх тухай сургалтанд 33 малчин, Монголын ХХАА-н хөгжлийн үндэсний нэгдлээс мал, малчинг хөгжүүлэх талаар зохион байгуулсан сургалтанд 18 малчныг тус тус хамруулсан.	100
		15	Эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж, бодлогоор дэмжиж, гахай, шувууны аж ахуйн тоог нэмэгдүүлнэ.	Жилдээ	Гахай, тахианы аж ахуйг өргөжүүлэхэд 1 иргэнд зээлийн дэмжлэг үзүүлнэ. Эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийг сургалтанд хамруулан, туршлага, судлуулж, чадавхижуулна.	СХС 3.5	Сумын хэмжээнд гахайн аж ахуй эрхлэгч-3 иргэн, тахиан аж ахуй эрхлэгч-2 иргэн байна. Эрчимжсэн мал аж ахуйн бүс нутагт гахай, шувууны аж ахуй эрхэлдэг 5 өрхөд нийт 1,25 га газрыг эзэмшүүлэн олгосны дагуу гахайн аж ахуй эрхлэдэг -2 иргэн нүүж гахайн байраа барьж төвлөрөөд байна.	70
6	Мал эмнэлэгийн чанар хүртээмжийг нэмэгдүүлж малын халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлнэ.	16	Мал, амьтныг ужиг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологийн дагуу хэрэгжүүлнэ.	Жилдээ	Ужиг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал, амьтныг хамруулна.	ОНХС 4.8	Сумын “ДЭОР” ХХК-тай гэрээ байгуулан мал, амьтны ужиг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологийн дагуу хийлгэж гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 13 нэр төрлийн вакциныг 171940 толгой мал, амьтанд хийж гүйцэтгэсэн. 2019 оны мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо, ажил үйлчилгээний хөлсийг ИТХТ-ийн 2018 оны 13 дугаар тогтоолоор батлуулсан.	100
		17	Шинээр гарч байгаа халдварт өвчний тандалт судалгааг хийнэ.	Жилдээ	Мэргэжлийн байгууллагуудтай хамтран шинээр гарч байгаа халдварт өвчний тандалт, судалгаа хийгдсэн байна.	ОНХС 3.0	Аймгийн ХХААГ-ын мал эмнэлгийн хэлтэстэй хамтран тандалт судалгаа хийхээр нийт 541 малаас 2 удаа цусны шинжилгээний дээж авч Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторит хүргүүлж давхар шинэжлүүлэхэд эерэг үзүүлэлттэй хариу ирсэн. Хүн амын хүнсний хэрэгцээнд сүү сүүн бүтээгдэхүүн нийлүүлдэг Шивээговь сумын 9 өрхийн малыг тандалт шинжилгээнд хамруулсан. Үүнээс 61 саалийн үнээ, 91 саалийн ямаа, 30 тэмээнд, 122 хээлтүүлэгчид бруцеллэзын шинжилгээ хийлгэхэд эерэг үзүүлттэй гарсан. 2018 онд ямын харшил сорилын шинжилгээнд 0,03 мянган толгой адуу, сүрьеэгийн шинжилгээнд 0,03 мян.тол үхэр тус тус бүрэн хамрагдсан.	100
		18	Мал эмнэлэгийн нэгжүүдийн дэмжиж, малын эм тарианы зохистой хэрэглээг	Жилдээ	Малын эм тарианы хэрэглээний талаар малчдад сургалт зохион байгуулна. Хүнсний зах, дэлгүүр, гар дээрээс борлуулагдаж байгаа	-	ХААИС-ийн багш нар, Монгол ВИ.И.ТИ.НЕТ төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан малын 10 төрлийн өвчнийг хэрхэн эмчлэх, ямар эмээр эмчлэх, малын биеээс эмийн бодис гадагшлах хугацааны тухай сургалтанд 33 малчин, Монголын ХХАА-н хөгжлийн	100

			нэвтрүүлж хяналт тавина.		малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах эмийн үлдэгдлийг тодорхойлж хяналт тавих ажлыг сайжруулан хүнсний бүтээгдэхүүний чанар, стандартыг хангуулна.		үндэсний нэгдлээс мал, малчинг хөгжүүлэх талаар зохион байгуулсан сургалтанд 18 малчныг тус тус хамруулсан. "ДЭОР" мал эмнэлгийн нэгж нь Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм тариагаар малчдад үйлчилж эмийн үлдэгдэлийн хугацаанд хяналт тавин ажиллаж байна.	
Газар тариалангийн чиглэлээр								
7	Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	19	Усалгаа тай газар тариаланг хөгжүүлж, техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, нэгж га-аас авах ургацыг нэмэгдүүлнэ.	Жилдээ	Аймгийн ХХААГ-ын газар тариалангийн тоног төхөөрөмжийг түрээсэлж ашиглахад дэмжлэг үзүүлнэ. Эргэлтийн талбайг 9.7 га-д хүргэн талбайн ашиглалтыг 80 цн/га-аас доошгүй хувьтай байлгана.	ХЭДС, СХС	Аймгийн ХХААГ-ын болон өөрийн тоног төхөөрөмжөөр 1-р багийн газар тариалан эрхлэгч 1 иргэн тоног төхөөрөмжийн цэг байгуулан хөрс боловсруулах, хаглах, борнойдох, үр суулгах үйлчилгээг 8 иргэний 12,5 га газарт хийж гүйцэтгэсэн. Сумын 3 иргэн төмс 3,8 га талбайд тариалж 29,4 тн ургац, хүнсний ногоо 3 га талбайд тариалж 64,237 тн ургац хураан авч иргэдийн хүнсний ногооны хэрэгцээнд нийлүүлсэн.	100
		20	Хүлэмжийн аж ахуйг дэмжиж, ургацыг нэмэгдүүлнэ.	Жилдээ	Шинээр 120 м2 талбай бүхий зуны хүлэмж, ашиглалтад орсон байна.	СХС 10.0	Хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлэхээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнийг хамруулан 120м ² - тай хүлэмжинд хүнсний ногоо тариалж 0,5 тн ургац хураан авсан.	100
		21	Чацаргана болон бусад жимс, жимсгэнэ тариалахыг дэмжинэ.	Жилдээ	Шинээр тариалах талбай 0.05 га-д чацаргана болон бусад жимс, жимсгэнэ 0.1 га-д тариалж, бойжилт 50 хувь байна.	ХХО 1.4	"Жимс жимсгэнэ" дэд хөтөлбөрийн хүрээнд 2 албан байгууллага, 2 ахмад настан, 4 хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхөд 60 чацаргана, 40 үхрийн нүд жимсний суулгацыг үнэ төлбөргүй олгож 0,032 га-д суулгуулсан. Өмнө жилүүдэд тариалсан 0.05га талбайн чацарганы суулгац жимсэлж 6 кг чацаргана хураан авсан.	100
Хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр								
8	Хөнгөн үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	22	"Итгэлийн зээл" олгож, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ.	Жилдээ	Үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах цэг байгуулсан байна. Зээлийн болон газрын бодлогоор дэмжсэн байна.	ЖДҮДС	Суманд "Түр худалдаа явуулах журам"-ын дагуу түр худалдаа явуулах зөвшөөрөлтэй талбайд худалдаа үйлчилгээ явуулах сүүдрэвчийг хийж байршуулан өөрийн сумын болон гаднаас ирсэн иргэд худалдаа үйлчилгээ явуулж байна. Итгэлийн зээлд хамрагдах хүсэлт гаргасан иргэн байхгүй байна.	70
		23	Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, борлуулалтыг дэмжинэ.	Жилдээ	Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний сав баглаа боодлыг сайжруулна. Үзэсгэлэн худалдааг уламжлал болгон зохион байгуулна. Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо, ХАҮТ-тай хамтран үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчилна.	Хөтөлбөр	ЖДҮ эрхлэгч иргэдийн үйл ажиллагааг дэмжиж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчилах, борлуулах зорилгоор "Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн" үзэсгэлэн худалдааг 2018 оны 09-р сард зохион байгуулж 13 иргэн 6 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнээр оролцож төрөл тус бүрийн ялагчийг тодруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Мөн аймгийн үзэсгэлэн худалдаанд 4 иргэн 3 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр амжилттай оролцсон. Суманд шинээр байгуулагдсан хэрчсэн гурилын цех болон цэвэр усны үйлдвэрийн үйл ажиллагаа, савлалтанд хяналт тавьж зөвлөн туслах үйлчилгээг 2 удаа үзүүлж ажилласнаар уг хоёр үйлдвэр хаяг болон савлагаандаа өөрчлөлт хийж сайжруулсан.	100

2.3. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар

2.4.Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, дэд бүтцийн салбар

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр

9	Газар зохион байгуулалтын менежментийг сайжруулж, газар олголтыг эрчимжүүлнэ.	24	Иргэнд газар өмчлүүлэх ажлыг хуулийн хугацаанд хэрэгжүүлнэ.	Жилдээ	Иргэнд газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлж тухайн жилийн төлөвлөгөөг 100% хэрэгжүүлсэн байна.	-	<p>Сумын 2018 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 2 байршилд 26.5 га газрыг 250 иргэнд сумын Засаг даргын 2018 оны А/56 дугаар захирамжаар өмчлүүлэн улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулсан. 2018 оны жилийн эцсийн байдлаар 2027 иргэн буюу сумын нийт хүн амын 58 % нь “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хуулийн дагуу 1 удаа үнэ төлбөргүй газраа өмчилж авсан байна.</p> <table border="1"> <caption>Газар өмчилж авсан иргэдийн тоо</caption> <thead> <tr> <th>Он</th> <th>Тоо</th> </tr> </thead> <tbody> <tr><td>2008 он</td><td>262</td></tr> <tr><td>2009 он</td><td>91</td></tr> <tr><td>2010 он</td><td>9</td></tr> <tr><td>2011 он</td><td>415</td></tr> <tr><td>2012 он</td><td>317</td></tr> <tr><td>2013 он</td><td>117</td></tr> <tr><td>2014 он</td><td>210</td></tr> <tr><td>2015 он</td><td>210</td></tr> <tr><td>2016 он</td><td>80</td></tr> <tr><td>2017 он</td><td>70</td></tr> <tr><td>2018 он</td><td>250</td></tr> </tbody> </table>	Он	Тоо	2008 он	262	2009 он	91	2010 он	9	2011 он	415	2012 он	317	2013 он	117	2014 он	210	2015 он	210	2016 он	80	2017 он	70	2018 он	250	100
		Он	Тоо																													
		2008 он	262																													
		2009 он	91																													
2010 он	9																															
2011 он	415																															
2012 он	317																															
2013 он	117																															
2014 он	210																															
2015 он	210																															
2016 он	80																															
2017 он	70																															
2018 он	250																															
25	Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгоно.	Жилдээ	Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг мөрдөж эхэлнэ.	-	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 07 дугаар тогтоолоор сумын 2018 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэн ажилласнаар хагас жилээр хангалттай үнэлэгдсэн. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт 11-р сарын байдлаар 90 хувийн хэрэгжилттэй байна.	100																										
26	Сумын төвийн гудамж талбай, албан байгууллага, айл өрхийг үе шаттайгаар хаягжуулна.	Жилдээ	Сумын төвийн айл өрх, албан байгууллагуудыг хаягжуулах ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ.	-	Сумын төвийн гудамж талбай, албан байгууллага, айл өрхийг үе шаттайгаар хаягжуулах ажлыг 2018 оны ОНХС-ийн 4,8 сая төгрөгийн хөрөнгөөр “Их эффект” ХХК-тай гэрээ байгуулан сумын төвийн орон сууцны 22 хаяг, орцны 53 хаяг, Объектын байрлал заасан 1 хаяг, байшин барилгын-33 хаяг нийт 108 ширхэг хаягийг хийж байршуулсан.	100																										
27	Газрын биржийн цахим системийг нэвтрүүлнэ.	Жилдээ	Газрын биржийн цахим системийг нэвтрүүлж иргэдэд үйлчилнэ.	-	Газрын цахим биржийг нэвтрүүлэн газартай холбоотой мэдээ мэдээллийг олон нийтэд ил тод болгох зорилгоор 2018 онд эзэмшүүлэх, барьцаалах, төсөл сонгон шалгаруулалтын зар, газрын зах зээлийн үнийн мэдээ зэргийг байршуулан ажилласан. Үүнд:																											

						<ul style="list-style-type: none"> ➤ Газар эзэмших эрхийн барьцаалбар -68 ➤ Газрын зах зээлийн үнийн 21 мэдээ -21 ➤ Төсөл сонгон шалгаруулалтын зар – 1-ийг тус тус газрын биржид бүртгэн ажилласан байна. Зураг 	70	
		28	Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлана.	Жилдээ	Иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшил, өмчлөл, ашиглалтын газрын эрхийн гэрчилгээг шинэчлэх, солих ажлыг 10%-д хүргэнэ.	ОНТ	Иргэн аж ахуй нэгж байгууллагын хувийн хэргийн нөхөн бүрдүүлэлтийн ажлыг зохион байгуулж зөрлөг хороололд газар олгосон 83-Иргэн, 6-ААНБ-ын материалыг засварлаад байна. Мөн Аймгийн ГХБХБГ-т нэгж талбарын хувийн хэргийн бүрдэлийг ханган хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна. 2018 онд иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлсэн 250 иргэний материалыг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэн ажиллаж байна. мөн 6 ААНБ-ын гэрээ, гэрчилгээг шинэчилсэн.	100
		29		Жилдээ	Лэнд менежер программ хангамжийг нэвтрүүлж эхэлсэн байна.	-	Газрын кадастрын мэдээллийн санг солбилцлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэн “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбилцол өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажлын хүрээнд ЛМ-2 программ хангамжийг нэвтрүүлэн ажиллаж байна. 2018 онд газрын кадастрын мэдээллийн сангийн 89 иргэн ААНБ-ын өгөгдлийг засварласан.	100
10	Хот суурин газрын дэд бүтцийг нэмэгдүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэн, хот тохижилтыг сайжруулна.	30	Суманд цэвэрлэх байгууламж байгуулж, саарал усыг эргүүлэн ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.	Жилдээ	Сумын төвд цэвэрлэх байгууламж байгуулахад шаардагдах зураг төсвийг шийдвэрлүүлнэ.	ОНХС 10.0	Аймгийн Засаг даргын 2018 оны А/125 дугаар “Ажлын хэсэг томилох тухай” захирамжаар суманд бага оврын цэвэрлэх байгууламж байгуулах ажлын судалгааг хийх, зургийн даалгавар боловсруулах ажлын хэсэг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж уг ажлын зураг төсвийг боловсруулах тооцоолол хийсэн боловч судалгаагаар зураг төсвийн зардал өндөр гарсан тул 2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийлгэхээр саналыг тусгаад байна.	40
		31	Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулна.	Жилдээ	Иргэдийн идэвхи, санаачлагыг дэмжиж, орцны дотор, гадна засвар, тохижилтын ажлууд хийгдэж эхэлсэн байна.	СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоотой хамтран нийтийн их цэвэрлэгээ, хурал цуглааныг хийж, орон сууцны гаднах сүүдрэвч, сандал, тоглоомуудыг засварлан ажилласан. СӨХ-ны дарга ажлаа өгсөн тул СӨХ 2 сарын хугацаанд эзэнгүйтэж 11-р сараас СӨХ-ны даргын асуудлыг шийдвэрлэн үйл ажиллагааг нь жигдрүүлсэн.	70
		32	Сумын хог хаягдлын менежментийг сайжруулна.	Жилдээ	Сумын айл өрхүүд, албан байгууллага аж ахуйн нэгжүүдийн хог хаягдлыг тээвэрлэх, төвлөрсөн хогийн цэгийн хогийг цэвэрлэж булна. Сумын айл өрхүүдийг хог хаягдлаа ангилан ялгах хогийн саваар хангах ажлын судалгаа хийнэ.	СОНХ С 15.0	2018 оны Орон нутгийн хөгжлийн сангийн 15.0 сая төгрөгийн хөрөнгөөр сумын төвийн албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хог хаягдлыг тээвэрлэх ажлыг “Илчлэг Шивээ” ОНӨҮГ-тай гэрээ байгуулж хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт тогтмол тээвэрлэн хүргэж байна. Мөн сумын төвийн төвлөрсөн хогийн цэгт шинээр 336 м3 нүх ухах, дүүрсэн нүхийг булах төвлөрсөн хогийн цэгийг цэвэрлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Нэртийн булаг, Бэхтийн булагийн орчны хог хаягдлыг түүж цэвэрлэх ажлыг 5 удаа зохион байгуулж 7 байгууллагын 130 гаруй ажилтан албан хаагчид хамрагдаж 21,4 м3 хог хаягдлыг түүж цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт ачиж зайлуулсан. Мөн Нийтийг хамарсан ажилд сумын ажилгүй 25 иргэнийг хамруулан Хаялга нуурын ойр орчмын 9 м3 хог хаягдлыг түүж цэвэрлүүлсэн.	100

						Сумын Засаг даргын 2018 оны А/18 тоот захирамжийн дагуу бүх нийтийн их цэвэрлэгээг 14 хоног тутам зохион байгуулж байна. 11-р сарын байдлаар нийтийн их цэвэрлэгээг 15 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 360 албан байгууллага, ААН-ийн 1300 иргэн 270м3 хог хаягдал цэвэрлэсэн байна. 4. Албан байгууллага, ААН-үүдэд сар бүр хог хаяглын төлбөрийн нэхэмжлэх тарааж хог хаягдал гаргасны төлбөрийг орон нутгийн орлогод төвлөрүүлэн ажилласнаар 11 сарын байдлаар 16500000 төгрөг төвлөрүүлэхээс 9823000 төгрөгийг төвлөрүүлж 60 хувийн гүйцэтгэлтэй байна.			
		33	Гэр хорооллын ус түгээх байрыг шинээр барьж, засварлан, ус түгээх авто машинаар хангана.	Жилдээ	Ус түгээх цэгүүдийг цахимжуулж зүүн гэр хорооллын байрны засвар хийж орчныг тохижуулна.	СОНХ С 10.0	2018 оны Орон нутгийн хөгжлийн сангийн 10 сая төгрөгийн хөрөнгөөр “Зүүн гэр хорооллын ундны усны байрыг цахимжуулах, худгийн байрыг засварлах” ажлыг “Сүмбэр зууч” ХХК-тай гэрээ байгуулж хийж гүйцэтгэн улсын комисс хүлээн авсан.	100	
Эрчим хүчний чиглэлээр									
11	Цахилгаан, дулааны эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлж, хэвийн үйл ажиллагааг хангана.	34	Сумын төвд иргэдийн өмчлөлд шинээр олгосон газруудын цахилгаан хангамжийг шийдвэрлэнэ.	Жилдээ	Иргэдийн өмчлөлд олгогдсон газарт цахилгаан татах ажлын зураг төсвийг боловсруулах хөрөнгийг шийдвэрлүүлнэ.	-	Сумын 2019 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр иргэдийн өмчлөлийн газарт цахилгаан шугам татах ажлын зураг төсвийг боловсруулах шугам татах ажлын саналыг оруулан эрэмбэлүүлсэн.	Үнэлэх боломжгүй	
Зам тээврийн чиглэлээр									
12	Орон нутгийн чанартай авто замын сүлжээг өргөтгөж, засварлана.	35	Ерөнхий төлөвлөгөөний дагуу сумын төвд авто зам тавьж, авто замын сүлжээг өргөтгөнө.	Жилдээ	Сумын төвд 2 км зам шинээр тавих зураг төсвийг хийлгэсэн байна.	ОНХС 6,0	Сумын төвөөс босоо тэнхэлгийн авто зам хүртлэх засмал замын ажлын зураг төсвийг 2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийлгэхээр иргэдийн саналыг авч нэгдсэн жагсаалтад эрэмбэлээд байна.	Үнэлэх боломжгүй	
		36	Сумын нийтийн эзэмшлийн талбайд явган зам, зогсоол, гэрэлтүүлгийн ажлыг үргэлжлүүлнэ.	Жилдээ	Сумын нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, үйлчилгээг хийнэ.	ОНХС 5.7	“Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар үйлчилгээ хийх”-ажлыг “Энхжих фармат” ХХК 5,74 сая төгрөгийн хөрөнгөөр 6,7-р байрны нарны зайн гэрлийн 7 аккумулятор, 4 гэрлийн цамхагын 24ш гэрэл, зүүн гэр хорооллын гудамжны 18 гэрлийг тус тус сольж комисст хүлээлгэн өгсөн. Сумын төв талбайн баруун талд авто зогсоол байгуулж замбараагүй байсан замуудыг хааж цэгцэлсэн.	100	

ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГО

3.1. Эрүүл мэндийн салбар

13	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулан, оношилгоо үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	37	Сумын эрүүл мэндийн төвүүдийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Жилдээ	Эрүүл мэндийн төвийг шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангана.	ОНХС 50.0	1. Орон нутгийн хөгжлийн сангийн 5 сая төгрөгийн хөрөнгөөр эрүүл мэндийн төвд “ЭХО томографик 4D аппарат худалдан авсан. Мөн Эрүүл мэндийн төвийн хөрөнгөөр сахарын 3ш аппаратыг 135000 төгрөгөөр худалдан авч, 2018 оны 11 сарын байдлаар эрсдэл бүхий 760 иргэн хамрагдахаас 92.5% буюу 703 иргэний сахарыг тодорхойлсон байна.	100
		38	Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, нялхсын эндэгдлийг бууруулна.	Жилдээ	Иргэдэд зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулна. Нялхсын эндэгдлийн суурь түвшин өмнөх оноос буурсан байна.	-	Сумын Хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн төвд нярайн 5 ширхэг иж бүрдэл, 100 удаагийн мазок шинжилгээний иж бүрдлийг 300000 төгрөгөөр худалдан авч зорилтот бүлгийн 100 эмэгтэйг шинжилгээнд хамруулсан. Мөн сумын иргэдийн хандиваар Эрүүл мэндийн төвд 660.000 төгрөгийн үнэтэй хүүхдийн судас тодосгогч аппарат, ШОХК-ийн 15 сая төгрөгийн хандиваар хүүхдийн тусламж үйлчилгээний 12 нэр төрлийн багц хэрэгслийг олгосон. Сумын эрүүл мэндийн төв нь эх нярайн хяналтыг сайжруулахын тулд төрсний дараах хяналтын үзлэгийг шинээр төрсөн эх, нярайд 7 хоног бүр хийж, товлолт вакцинжуулалтанд хамруулж ажилласнаар нялхсын эндэгдэл гараагүй болно. 2018 оны 11 сарын байдлаар нийт 74 эх хяналтанд байгаа бөгөөд шинээр 39 эмэгтэйг жирэмсний эрт хяналтанд авч, давхардсан тоогоор 316 удаа үзлэгт хамруулсан байна. Мөн шинээр төрсөн 55 эхэд 416 удаагийн гэрийн эргэлт хийж ажилласан. Мөн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 6 сэдвийн хүрээнд нийт 136 эмэгтэйд зохион байгуулсан.	100
		39	Зонхилон тохиолдох В, С вирус, сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, хорт хавдрыг эрт илрүүлж, өвчлөл, нас баралтыг бууруулна.	2018-2020 ОНХС	Эрүүл мэндийн төвийг зонхилон тохиолдох В, С вирус, сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, хорт хавдрыг эрт илрүүлэх ажлыг үргэлжлүүлнэ. Эрт илрүүлгийн үзлэгийн хувь: Вируст гепатит - 20%, сүрьеэ - 10%, БЗДХ/ХДХВ - 15%, хөхний хавдар -57%, умайн хүзүүний хавдар-60%	СОНХ С	Монгол улсын Засгийн газрын тогтоолоор “Элэг бүтэн Монгол-2” үндэсний хөтөлбөрийн хүрээнд сумын хэмжээнд 15-39 насны 1461 иргэн хамрагдахаас 861 иргэн буюу 60%-ийг шинжилгээнд хамруулж, зорилтот бүлгийн 827 иргэнд гарын авлага тарааж эрүүл мэндийн боловсрол олгосон. Элэгний В вирустай 45, С вирустай 21, нийт 66 иргэнийг аймгийн нэгдсэн эмнэлгийн халдвартын эмчийн хяналтанд илгээсэн. Сумын “Хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ аймгийн диспансерийн хяналт, аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран сүрьеэ өвчний эрт илрүүлгийн шинжилгээ оношилгоог 450000 төгрөгийн төсөвтэйгээр 10 дугаар сард зохион байгуулж, сумын 416 иргэнийг рентген шинжилгээнд, уушигны эмгэг, сэжиг бүхий 45 иргэнийг цэрний шинжилгээнд тус тус хамруулж, сорьцыг ХӨСҮТ-д хүргүүлээд байна. Аймгийн Засаг даргын захирамжаар зарлагдсан “Цус эрүүл бол бие эрүүл” аяны хүрээнд 2018 оны 10 сарын 30-ны өдрийн байдлаар нийт 1872 иргэн хамрагдахаас 1010 иргэн буюу 54%-ийг хамруулж, шинжилгээний дээжийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүргүүлээд байна. Графикаар	100

						<p>харьцуулбал:</p> <p>2018 оны 10 сарын 30-ны өдрийн байдлаар хөхний хавдраас урьдчилан сэргийлэх үзлэгт 1006 эмэгтэй хамрагдахаас 799 эмэгтэй буюу 79.4%, умайн хүзүүний эсийн шинжилгээнд 125 иргэн хамрагдахаас 104 эмэгтэй буюу 83%-ийн хамрагдалттай байна. Хамрагдаагүй шалтгааныг тодруулбал умайн хүзүүний эсийн шинжилгээнд хамрагдах товлот хугацаа болоогүй 21 иргэн, хөхний хавдраас урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаагүй иргэдийн дийлэнх хувийг суманд харьяалалтай боловч өөр орон нутагт түр оршин сууж буй иргэд эзэлж байна.</p>	
--	--	--	--	--	--	--	--

3.2. Боловсрол, соёл урлаг, спортын салбар

Боловсролын чиглэлээр

14	40	Сургууль, цэцэрлэгийн барилгыг өргөтгөж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Жилдээ	Сумын 3-р сургуулийн 640 хүүхдийн шинэ барилгын ажлын хөрөнгийг дээд шатны байгууллагад уламжлана. 3-р цэцэрлэгийн 150 хүүхдийн өргөтгөлийн барилгын холболтын зураг төсвийг хийлгэнэ.	-	Сумын 2019 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтад 3 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг төсвийг боловсруулах саналыг авч нэгдсэн жагсаалтад эрэмбэлээд байна. Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт улсын төсвийн 4.7 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Шивээговь сумын 3-р сургуулийн 640 хүүхдийн шинэ барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөгдсөн.	Үнэлэх боломжгүй
	41	Сургууль цэцэрлэгийн орчинг тохижуулна.	Жилдээ	Гэр цэцэрлэгийн сургалтын орчинг тохижуулна.	ОНХС 6.0	3-р цэцэрлэгийн гадна талбайн тохижилтыг ШОХК-ийн 7.6 сая төгрөг, байгууллагын хөрөнгөөс 1.6 сая төгрөгийг зарцуулж цэцэрлэгийн гадна талбайг тохижуулсан. Мөн 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр гэр цэцэрлэгт 1 гэр, 30 ш гудас, хөнжил болон 60 хос цагаан хэрэглэлийг “Оч хийц” ХХК-тай гэрээ байгуулж, 6027100 төгрөгөөр худалдан авсан. Мөн цэцэрлэг өөрсдийн хөрөнгөөрөө гэр цэцэрлэгтээ үүдний амбаар барьсан. Сургуулийн гадна талбайн тохижилтыг 1.5 сая төгрөгийн төсөвтэйгээр тохижуулсан. Үүнд: “Төгсөгчдийн төгөл” ногоон байгууламжийг хашаажуулж, сургуулийн үүдний хэсэгт бетон зутгаж, сандал хийж тохижуулсан.	100
	42	Сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлж,	Жилдээ	Сургуулийн дотор цахилгааны шугамын хэсэгчилсэн шинэчлэлийг хийнэ.	С ОНХС 20.0	Сургалтын цөм хөтөлбөрийг аймгийн хэмжээнд нэгдсэн журмаар боловсруулан мөрдөн ажиллаж байна. 3-р цэцэрлэгийн Заах аргын нэгдлээс бүх бүлэгт Тоглонгоо	

			сургалтын хэрэглэг дэхүүн, тоног төхөөрөмжөөр хангана.				суралцья, Ахлах бүлгүүдэд STEAM тоглоом, бэлтгэл болон дунд бүлгүүдэд Төсөлт тоглоом зэрэг сургалтын шинэлэг төсөлд суурилан суралцахуйн арга зүйн технологийг хэрэгжүүлж байна “Тоглонгоо суралцах арга зүйн технологи”-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цэцэрлэгийн сурах бичиг номыг ЗАН-ийн багш нар хамтран боловсруулан хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2018-2019 оны хичээлийн жилд суурь боловсролд цөм хөтөлбөр 4 дэх жилдээ, бага дунд бүлгүүдэд цөм хөтөлбөр 3 дахь жилдээ хэрэгжиж, 1-5-р ангийн сургалтын цөм хөтөлбөрийг аймгийн хэмжээнд нэгдсэн хөтөлбөрийн дагуу сургалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлж байна. Мөн энэ хичээлийн жилд бага боловсролын хүрээнд STEAM хөтөлбөрийг 7 хоногт 2 цагаар, IV-XII ангид эрүүл мэндийн хичээлийг 7 хоногт нэг цагаар, ахлах ангиудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг тус тус хэрэгжүүлж байна. Мөн “3-р сургуулийн цахилгааны монтажыг хэсэгчлэн шинэчлэх”-ажлыг “Энхжих формат” ХХК хийж гүйцэтгэж улсын комисст хүлээлгэн өгсөн.	100
Соёл урлаг, спортын чиглэлээр								
15	Соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ	43	Соёл, урлагийг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Жилдээ	Сумын орон нутаг судлах танхимын тохижилтыг хийж, үзмэрийн сан хөмрөгийг нэмэгдүүлнэ.	ОНХС 3,0	Соёл, урлагийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэхээр 3 зорилтын хүрээнд 6 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэнээр 70 хувийн биелэлттэй ажилласан. Хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу морин хуураар 3 сурагч идэвхтэй хичээллэж, мэргэжлийн багшийн хангалтгүйгээс уртын дуу, морин хуурын сургалт шинээр хийгдээгүй боловч Ерөнхий боловсролын сургуулийн урлагийн үзлэгийн төрөлд дээрх 2 төрлийг оруулж, сурагчдыг идэвхжүүлж ажилласан. Орон нутаг судлах танхимын сан хөмрөгийг баяжуулах ажлыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж үзмэрийг нэмэгдүүлсэн. Аймгийн Засаг даргын нэрэмжит “Боржигон түмний дуулал-2018” урлагийн наадамд сумаас 40 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг бүрдүүлэн оролцож Шилдэгээр шалгарсан. Нийтийн номын сангийн фонд болон орон нутаг судлах танхимыг тохижуулах ажлын хүрээнд ОНХС-ын 10 сая төгрөгийн хөрөнгөөр 5 ширээ, 10 сандал, орон нутаг судлах танхимд 8 нэр төрлийн үзмэрийг /амьтны чихмэл/ 1,5 сая төгрөгөөр худалдан авсан. Үүнд: Чоно, Үнэг, Дорго, Унага, Зурам, Өмхий хүрэн, ятуу шувуу, Турлиах хэрээ зэрэг болно. Мөн орон нутаг судлах танхимд цонх гаргаж вакум цонх хийлгэсэн.	100
		44	Боржигон өв соёл, уртын дуу, морин хуурын сургалт, суртал чилгааг эрчимжүүлнэ.	Жилдээ	Боржигон морин хуур, боржигон уртын дууны сургалтыг зохион байгуулна.	БТ	2017-2018 оны хичээлийн жилд Боржигон морин хуураар сургуулийн 20 сурагч хичээллэж, сумын 1-р багийн иргэн уртын дууч О.Алтанхүү ЕБС-ийн 10 сурагчид Боржигон уртын дууг зааж сургаснаар аймагт зохион байгуулагдсан “Боржигон морин хуур”-ын уралдаанд ЕБСургуулийн 11-р ангийн сурагч н.Наранмандах тэргүүн байр эзэлсэн.	

							Хүүхэд, багачуудад Боржигон өвийг сурталчилж, сургах зорилгоор жил бүрийн сурагчдын урлагийн үзлэгийн төрөлд Боржигон морин хуур, уртын дууны төрлийг оруулж, хүүхэд залуучууд төдийгүй эцэг эхчүүдэд сурталчилж ажилласан. Мөн сумын баяр наадмаар Боржигон морин хуур, уртын дууг сурталчилан мэндчилгээ дэвшүүлсэн.	100
16	Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин нөхцлийг бүрдүүлж, материаллаг баазыг нэмэгдүүлнэ.	45	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Жилдээ	Тухайн жилийн төлөвлөгөө ний хэрэгжилт 100%	ОНХС	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг 1 зорилтын хүрээнд 7 ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн хэрэгжүүлж ажилласнаар 100 хувийн биелэлттэй байна. Төлөвлөгөөний дагуу суманд нийт мэргэжлийн багш дасгалжуулагч 3, спортын зэрэг цолтой 3 иргэн 5 төрлийн дугуйлан, секц хичээллүүлж, хүн амын 8 хувь буюу 286 иргэн /“Хаялга” спорт клубт 146 сурагч, 100 буудалт даам, шатрын дугуйланд 40 сурагч, XS спиннинг клубт 60 иргэн, иог дасгалын анхан шатны курст суралцсан 40 иргэн/ тогтмол дасгал хөдөлгөөнөөр хичээллэж, ажлын байрны дасгал хөдөлгөөнөөр сумын Эрүүл мэндийн төвийн 20 ажилтан хичээллэж байна. Биеийн тамираар тогтмол хичээллэгсэд нийт хүн амын 5.5%, дунд зэргийн дасгал хөдөлгөөнөөр хичээллэгсэд нийт хүн амын 2.9%-ийг эзэлж байна. “Хаялга” спорт клубын тамирчид бүс улс, олон улсын чанартай тэмцээн уралдаанаас нийт 11 алт, 9 мөнгө, 22 хүрэл медаль тус тус хүртсэн байна. Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд 267 иргэн, 608 сурагчийг буюу хүн амын 26%-ийг хамруулсан байна.	100
		46		Жилдээ	Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын үйл ажиллагааг тогтмолжуулж, үзүүлэлтийг сайжруулна.	ОНХС 5.0	2018 онд албан байгууллага бүр дээр Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг 5, 10 дугаар сард зохион байгуулж, нийт 6 байгууллагын 267 албан хаагч болон Ерөнхий боловсролын сургуулийн 608 сурагчийг хамруулж сорилын мэдээг нэгтгэн аймгийн Биеийн тамир, спортын газарт хүргүүлсэн.	100

3.3. Хүн ам, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын салбар

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр

17	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулна.	47	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, үр ашгийг дээшлүүлж ажилгүйдлийг бууруулна.	Жилдээ	Байнгын ажлын байранд 70, түр ажлын байранд 50-аас доошгүй иргэнийг хамруулсан байна.	ХЭДС	<p>Сумын ажилгүй 154 иргэний мэдээллийг мэдээллийн санд оруулж 79 иргэнийг түр ажлын байранд 104 иргэнийг байнгын ажлын байранд нийт 182 иргэнийг ажлын байранд зуучилсан байна.</p> <p style="text-align: center;">АЖЛЫН БАЙР</p> <table border="1"> <caption>Ажлын байр (Байнгын / Түр)</caption> <thead> <tr> <th>Дүүргийн нэр</th> <th>Байнгын</th> <th>Түр</th> </tr> </thead> <tbody> <tr><td>ШОХК</td><td>68</td><td>14</td></tr> <tr><td>ЭДТГ</td><td>34</td><td>32</td></tr> <tr><td>Соёлын төв</td><td>1</td><td>7</td></tr> <tr><td>Сургууль</td><td>48</td><td>3</td></tr> <tr><td>'Илчлэг-Шивээ'</td><td>5</td><td>25</td></tr> <tr><td>ХХҮГ-ын...</td><td>20</td><td>1</td></tr> <tr><td>Ямаа самнах...</td><td>1</td><td>1</td></tr> <tr><td>Нийтийг хамарсан Бүрэн Урлан ХХК</td><td>13</td><td>1</td></tr> <tr><td>Страто ХХК-д</td><td>13</td><td>1</td></tr> </tbody> </table>	Дүүргийн нэр	Байнгын	Түр	ШОХК	68	14	ЭДТГ	34	32	Соёлын төв	1	7	Сургууль	48	3	'Илчлэг-Шивээ'	5	25	ХХҮГ-ын...	20	1	Ямаа самнах...	1	1	Нийтийг хамарсан Бүрэн Урлан ХХК	13	1	Страто ХХК-д	13	1	100
Дүүргийн нэр	Байнгын	Түр																																				
ШОХК	68	14																																				
ЭДТГ	34	32																																				
Соёлын төв	1	7																																				
Сургууль	48	3																																				
'Илчлэг-Шивээ'	5	25																																				
ХХҮГ-ын...	20	1																																				
Ямаа самнах...	1	1																																				
Нийтийг хамарсан Бүрэн Урлан ХХК	13	1																																				
Страто ХХК-д	13	1																																				

18	Зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэн, ядуурлыг бууруулна.	48	Зорилтот бүлэгт чиглэсэн дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Жилдээ	Сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хамруулах, ажлын чиг баримжаа олгох, хөнгөлөлттэй зээл, тусламжид хамруулж, нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлнэ.	ОНХС	<p>Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 03-р сарын 15-ны өдрийн 11 тоот тогтоолоор Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт хамрагдах 16 өрхийг батлуулж 2018 оны 03-р сард Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт хамрагдаж байгаа 16 өрхийн төлөөлөлд “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах” сургалтыг зохион байгуулж “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-г боловсруулан ажиллахад заавал хөгжих өрх 2, хөгжлийн төлөөх өрх 12, хөгжлийг дэмжигч өрх 2 байсныг 11-р сарын 20-ны өдөр жилийн эцсийн үнэлгээг хийж заавал хөгжих өрх байхгүй, хөгжлийн төлөөх өрх 9, хөгжлийг дэмжигч өрх 4, хөгжлийг бүтээгч өрх 3 болж өөрчлөгдөн 7 өрхийн түвшин ахисан үзүүлэлттэй байна.</p> <p>Зорилтот бүлгийн 34 иргэнийг урьдчилан сэргийлэх ДОХ, ХДХВ, Сүрьеэгийн үзлэг шинжилгээнд 2018 оны 10-р сард хамруулсан. Мөн зорилтот 16 өрхийн 80 гишүүнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.</p> <p>Газраа өмчилж аваагүй зорилтот бүлгийн 12 иргэнийг хуулийн дагуу өмчлөлийн газартай болгоод байна.</p> <p>Зорилтот өрхийн 0-18 насны 15 хүүхэд ЕБС-д, 8 хүүхэд, СӨБ-д бүрэн хамрагдаж байна.</p> <p>Зорилтот өрхийн хөдөлмөрийн насны 45 гишүүний 23 гишүүн нь ажлын байртай болсноос 6 иргэнийг байнгын ажлын байранд, 4 иргэнийг бүлгийн ногоо, 9 иргэнийг нийтийг хамарсан ажилд зуучлан 2205000 төгрөгийн цалинг олгосон. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох ажлын хүрээнд – 1 иргэнд 5 сая төгрөгийг олгож үйл ажиллагаагаа явуулж байна. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд</p> <p>Зорилтот 16 өрхөөс 4 өрхийн 24 гишүүн 1-7-р сард “Хүнсний эрхийн бичиг”-ийн үйлчилгээнд хамрагдаж байгаад 8-р сараас эхлэн дахин 2 өрхийн 13 гишүүн нэмэгдэж нийт 6 өрхийн 37 гишүүнд 1-11-р сарын 4424000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг олгосон.</p> <p>Нийгмийн халамжийн үйлчилгээнд 27 иргэнийг хамруулан 18939000 төгрөгийг олгосон байна. Мөн Аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгч Г.Гэрэлхүү, Л.Гэрэл нар 1-р багийн хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнд “Оргил” рашаан сувилалд сувилуулах зардалд 600.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>“Хүнсний эрхийн бичиг”-ийн шийтгэгдсэн журам, “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох”, “Гэр бүлийн аз жаргал”, “Гэр бүлийн хүчирхийлэлттэй тэмцэх тухай хууль”, “Нийгмийн халамжийн тухай хуулийн Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ” зэрэг сэдвээр 6 удаагийн сургалтанд хамруулсан.</p>	100
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр								
19	Гэр бүл,	49	Гэр бүл, хүүхэд	Жилдээ	Хүүхэд хамгааллын хамтарсан	ОНХС	1. Сумын гэр бүл, хүүхэд хамгааллын Хамтарсан багийн	

	хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.		хамгааллын хариу үйлчилгээ үзүүлнэ.		багийн үйл ажиллагааг жигдрүүлнэ. Хамтарсан багийн гишүүдийг сургалтанд хамруулж туршлага судлуулна.		2018 онд хийх ажлын төлөвлөгөөг 5 зорилт 17 арга хэмжээг хийж гүйцэтгэхээр төлөвлөн батлуулсан. 2. 2018 оны жилийн эцсийн байдлаар Хамтарсан багийн шуурхай хурлыг 11 удаа зарлан хуралдуулж, шинээр 9 кейс дээр ажилласан. Хамтарсан багийн халамжийн үйлчилгээг 2 иргэнд, холбон зуучлах үйлчилгээг 7 иргэнд үзүүлж, мэргэжлийн сэтгэл зүйчийн зөвлөгөөнд 3 гэр бүлийг хамруулсан. Төлөвлөгөөний биелэлт 100 хувийн хэрэгжилттэй ажилласан байна. 2017 онд гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл бүртгэгдээгүй бөгөөд 2018 онд гэр бүлийн хүчирхийлэл 1, хүүхдийн эсрэг хүчирхийлэл 2 бүртгэгдэж, хуулийн байгууллагад холбон зуучилсан.	100	
		50	“Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Жилдээ	Суманд хэрэгжүүлж байгаа “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлын чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ	ОНХС	Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг 3 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг төлөвлөн төлөвлөгөөний дагуу аян-1, тэмцээн уралдаан-4, сургалт-2, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг-2. соёл урлагийн арга хэмжээ-2 тус тус зохион байгуулж, нийт 40 гаруй хүүхэд залуусыг дэмжиж ажилласан байна.	100	
		51	Зорилтот бүлгийн гишүүдийг хөнгөлөлттэй үнээр тээвэрлэх, нийтийн тээврийн бодлогыг хэрэгжүүлнэ.	Жилдээ	Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөнгөлөлттэй үнээр тээвэрлэхэд шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлэх ажлыг эхлүүлнэ.	ОНХС 1.0	УБТЗ-ын хөдөлгөөн хариуцсан орлогч дарга н.Цогтбаяртай сумын удирдлагууд уулзаж, хүсэлт тавьсны дагуу Сайншанд чиглэлийн 1 купейн 8 суудлыг 22-р зөрлөгөөс сууж буй хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд билет бичиж үйлчлэхээр болсон. Шивээговь сумаас Говьсүмбэр аймаг, Улаанбаатар хотын чиглэлд албан ёсны нийтийн тээврийн үйлчилгээ явдаггүй болно.	40	
Дөрөв. Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого									
4.1. Байгаль орчин, хүний эрүүл мэндэд ээлтэй ногоон хөгжлийн чиглэлээр									
20		52	Хуримтлагдсан хур хог, хаягдал, туурь балгасыг цэвэрлэж нөхөн сэргээнэ.	Жилдээ	Туурь балгас, хур хог хаягдалыг цэвэрлэх хөрөнгийг шийдвэрлүүлнэ.	-	Сумын хэмжээний хур хог хаягдал, туурь балгастай талбайн судалгааг гаргахад 4,2 га талбай байна. Зориулалтын бус газар хог хаягдал хаяж байсан 2 иргэнийг илрүүлж хогийг төвлөрсөн хогийн цэгт ачиж зайлуулсан. Сумын туурь балгас, хур хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийлгэхээр БИНХ-аар хэлэлцүүлэн эрэмбэлүүлээд байна.	70	
4.2. Экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгаль хамгаалах ажилд бүх нийтийн оролцоог хангах чиглэлээр									
21	Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалж, зохистой ашиглана.	53	Булаг, шанд, рашааны эхийг хамгаална.	Жилдээ	Тооллогын ажлыг зохион байгуулж, мэдээллийн санг шинэчилнэ. Булаг шандны хамгаалалтыг сайжруулсан байна.	БХНСА ХЗ 3.0	Худаг уст цэгийн тооллогын ажлыг 11-р сард зохион байгуулж тооллогоор 54 бэлчээрийн худаг, 6 төв суурингийн худаг 5 нуур, 5 булаг, 42 уурхайн худаг нийт 112 уст цэг тоологдсон байна. “Бэхтын булаг”-ыг эхийг шинээр хашаажуулах ажлыг зохион байгуулсан. Мөн Нэртийн булаг, Бэхтийн булгийн орчны хог хаягдлыг түүж цэвэрлэх ажлыг 5 удаа зохион байгуулж 7 байгууллагын 130 гаруй ажилтан албан хаагчид хамрагдаж 21,4 м3 хог хаягдлыг түүж цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт ачиж зайлуулсан. Мөн Нийтийг хамарсан	100	

						ажилд сумын ажилгүй 25 иргэнийг хамруулан Хаялга нуурын ойр орчмын 9 м3 хог хаягдлыг түүж цэвэрлүүлсэн.		
		54	Сумдын ундны усны эх үүсвэрийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авч, хамгаалалтын горимыг мөрдүүлнэ.	Жилдээ	Сумын ундны усны эх үүсвэрийг орон нутгийн хамгаалалтанд авч, тэжээгдлийн мужаар тэмдэгжүүлэн, эрүүл ахуйн дэглэм мөрдүүлнэ.	АБХНС АХЗ 3.0	Сумын ундны усны эх үүсвэр алсын 1, 2-р худгийг ИТХ-ын 2018 оны 12 дугаар тогтоолоор Орон нутгийн тусгай хамгаалалтанд авч, ундны усны эх үүсвэрт эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэн ажиллаж байна.	100
22	Байгаль орчныг хамгаалж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглан, ашиглалтыг сайжруулах ад олон нийтийн оролцоог хангана.	55	Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Жилдээ	Байгаль орчны хууль тогтоомжуудыг сурталчлах, байгаль хамгаалах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, нөлөөллийн арга хэмжээнүүдийг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.	АБХНС АХЗ 5.0	Аймгийн БОАЖГ-аас зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөг болон сумын Нээлттэй хаалганы өдөрлөг, багийн Иргэдийн нийтийн хурлын үеэр давхардсан тоогоор 317 иргэнд зөрчлийн тухай хууль болон байгаль орчны чиглэлээр гарын авлага бэлтгэж тараасан. Мөн Сумын ААНБ болон айл өрхүүдээр хууль сурталчилах “Аялах хайрцаг” аялуулж түүнд Зөрчлийн тухай хуулийн байгаль орчинтой холбоотой хэсгүүд болон Хог хаягдлын тухай хууль, ашигт малтмалын тухай хууль, ан амьтны тухай хууль зэрэг хуулиудаар гарын авлага бэлтгэн аялуулж байна. Бүх нийтээр мод тарих өдөр, бүх нийтийн их цэвэрлэгээг албан байгууллага, аж ахуйн нэгж иргэдтэй хамтран зохион байгуулж байна.	100
23	Ногоон бүс, ойн зурвас байгуулан газрын хөрсийг нөхөн сэргээх замаар байгаль орчны доройтлыг сааруулна.	56	Сумын төвд ногоон байгууламжийн бичил цэцэрлэг байгуулна.	Жилдээ	Сумын төв талбайн өнгө үзэмжийг сайжруулж ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ. Сумын төвийн зам дагуу таригдсан мод болон нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн усалгаа арчилгааг сайжруулна.	ОНХС 2.0	2018 оны Орон нутгийн хөгжлийн сангийн 1,9 сая төгрөгийн хөрөнгөөр “Сумын нийтийн эзэмшлийн төв талбайн засвар, тохижилт”-ын ажлыг иргэн Г.Золбоотой гэрээ байгуулж хийж гүйцэтгүүлсэн. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг 05, 10-р сард зохион байгуулж давхардсан тоогоор 22 аж ахуйн нэгж байгууллага нийт 989 мод шинээр тарьсанаас цэцэрлэгт хүрээлэнд нөхөн сэргээлт хийж 313 мод тарьсан. Орон нутгийн хөгжлийн сангийн 2.0 сая төгрөгийн хөрөнгөөр сумын төвийн нийтийн эзэмшлийн ногоон байгууламжуудын усалгаа, арчилгааны ажлыг “Илчлэг Шивээ” ОНӨҮГ хийж гүйцэтгэн комисст хүлээлгэн өгсөн.	100
24		57	Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлнэ.	Жилдээ	Эргүүл шалгалтын ажлыг тогтмол зохион байгуулж зөрчлийг арилгуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	АБХНС АХЗ	Сумын Засаг даргын 2018 оны 06-р сарын 04 өдрийн “Эргүүл шалгалтын ажил зохион байгуулах тухай” А\85 дугаар захирамжаар хаялга нуурын орчимд 6-р сарын 07-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаанд 10 удаагийн эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулж амарч зугаалж байгаа иргэдэд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг өгч ажилласан. Мөн Аймгийн БОАЖГ, МХГ, ОБГ болон сумын цагдаагийн хэсэгтэй хамтран хөдөөгийн айл өрхүүдээр эргүүл шалгалтын маршрут гарган 5 удаа 1500 гаруй км газарт зохион байгуулсанд ямар нэгэн зөрчил илрээгүй болно.	100

4.3. Аялал жуулчлалын салбар

25	Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлж, менежментийг боловсронгуй болгож, материаллаг баазыг бэхжүүлнэ.	58	Аялал жуулчлалыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Жилдээ	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 100% байна.	-	Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэхээр 4 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж төлөвлөгөөний хэрэгжилт 11-р сарын байдлаар 90 хувийн биелэлттэй байна. Төлөвлөгөөний дагуу сумын түүх соёлын үл хөдлөх дурсгал болох “Зуун умай” хөшөөний хамгаалалтын хашааг сэргээн засварлаж хөшөө дурсгалын түүхийн талаарх мэдээллийн самбарыг шинээр байршуулан ажилласан. Мөн “Бэхтын булаг”-ыг эхийг шинээр хашаажуулах ажлыг зохион байгуулсан. Нэртийн булгийг 2 дугаар багийн малчинтай гэрээ байгуулж хариуцуулсан. 2018 онд соёлын биет бус өвийг тээгч иргэдийн судалгааг гаргаж, соёлын биет бус өв тээгчдийг улсын болон орон нутгийн уралдаанд оролцход нь дэмжлэг үзүүлсэн.	100
		59	Аяллын маршрутын дагуу түр буудаллах цэгүүдийг байгуулна.	Жилдээ	Улсын чанартай авто зам, аялал жуулчлалын маршрутын дагуу түр буудаллах цэг байгуулах ажлыг судлана.	-	Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд “Хаялга” нуурын орчимд түр буудаллах цэг байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	40
		60	Түүх, соёлын өвийг сэргээж хамгаална.	Жилдээ	Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газруудыг малчин иргэдэд гэрээгээр эзэмшүүлж эзэнжүүлнэ.	-	Түүх соёлын үл хөдлөх дурсгал болох “Зуун умай” хөшөө, Нэртийн булгийг малчин иргэдтэй гэрээ байгуулж хариуцуулсан. “Зуун умай” хөшөө дурсгалын хамгаалалтын хашааг сэргээн засварлаж, танилцуулга байршуулж тэмдэгжүүлэх ажлыг сумын “Хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийн 100000 төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн.	100

ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

5.1. Тогтвортой, хариуцлагатай эрх зүйт төрийг төлөвшүүлэх чиглэлээр

26	Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ.	61	Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйг сайжруулахад чиглэсэн аймгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Жилдээ	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь хангагдсан байна.	АОНХ С	Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйг сайжруулахад чиглэсэн аймгийн дэд хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэхээр 2 зорилтын хүрээнд 7 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажилласнаар 100 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
		62	Төрийн албан хаагчдын авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөл, мэргэжил, ур чадварыг дээшлүүлж, чадавхи жуулна.	Жилдээ	Төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна. Мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулсан байна. Төрийн албаны туршлагыг судлан нэвтрүүлнэ.	ОНХС БТ	Сумын төрийн албан хаагчдад авилгын эсрэг хуулиар гарын авлага бэлтгэн тараасан. Мөн авлигын эсрэг зурагт хуудсуудыг мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна. ЗДТГ нь “Сургалт” хөтөлбөрийг 4 жилээр боловсруулан батлуулж жил бүр хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу ажлын байрны-13 сургалт, орон нутагт зохион байгуулагдсан 20 гаруй сургалт, бусад аймаг, нийслэлд зохион байгуулагдсан – 39 сургалтанд албан хаагчдаа бүрэн хамруулсан. Мэргэжил дээшлүүлэх 10 хоногийн сургалтанд 2 албан хаагчийг хамруулсан. Мөн Улаанбаатар хотын Налайх дүүргийн ЗДТГ-тай туршлага судлах арга хэмжээг 5-р сард зохион	100

						байгуулсан.		
27	Төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган, төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, чанартай хүргэнэ.	63	Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Жилдээ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг иргэдэд тайлагнана. Өргөдөл гомдлыг шийдвэрлэх хугацаа 2 дахин багассан байна. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс санал авч, үр дүнг үнэлнэ.	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг ИТХ-ын 2018 оны 08 дугаар тогтоолоор батлуулж сумын вэб сайтад байршуулан ажиллаж байна. Мөн Засаг даргын Тамгын газрын 2017 он, 2018 оны хагас жилийн ажлын тайланг эмхэтгэл болгон бэлтгэж 200 гаруй иргэдэд тарааж ажилласан. Малчдын нэг өдөр өдөрлөгийг зохион байгуулж сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тайланг малчдад тайлагнасан. 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт нийт 1145 өргөдөл ирсэнээс 1131 өргөдлийг 15 хоногийн хугацаанд шийдвэрлэж 7 өргөдлийг 30 хоногийн хугацаанд, газар хүссэн 3-н өргөдлийн хугацааг 30 хоногор сунган шийдвэрлэж 4 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна. Сумын нээлттэй хаалганы өдөрлөгөөр 112 иргэнээс төрийн үйлчилгээ болон төрийн албан хаагчдын харилцаа, ёс зүй, цаг баримтлалын талаар санал асуулга авч ажиллахад сайн үнлэгдсэн.	100	
5.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах чиглэлээр								
28	Иргэдийн амгалан тайван, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ	64	Гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх олон нийтийг хамарсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Жилдээ	Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангуулж, мэргэжлийн ангиудыг бэхжүүлж, чадавхижуулна.	ОНХС 0.5-	Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолын дагуу “Газар хөдлөлтийн дуут дохио”-гоор ажиллах дадлага сургуулийг зохион байгуулж сумын 13 аж ахуйн нэгж, байгууллага, 1, 2-р багийн нийт 847 иргэн, 56 авто машин хамрагдсан. Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын дагуу нүүлгэн шилжүүлэх ажилд 56 автомашины бэлэн байдлыг хангаж ажилласан. Сумын “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-ний дагуу “Газар хөдлөлтийн тухай ойлголт, дуут дохиогоор ажиллах заавар” сэдэвт сургалтыг иргэдийн дунд зохион байгуулж 21 иргэн хамрагдсан. Мөн ОНХС-ийн 250000 төгрөгийн хөрөнгөөр “Хаялга” нуурын зүүн хойно, баруун урд талд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэх самбарыг байршуулсан. Бэлчээрт тандалт судалгаа хийж сумын нутаг дэвсгэрийн оготно мэрэгч ихтэй газрын байршлыг тогтоож ОНХС-ийн 1 сая төгрөгийн хөрөнгөөр 10 цэгийн 12 га газар, Улсын төсвийн 3,2 сая төгрөгийн хөрөнгөөр 8 цэгийн 2000 га газарт тус тус хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг энгийн, механик, биологийн аргаар зохион байгуулж ажилласан.	100
		65	Цэргийн болон улсын дайчилгааны даалгаврын хэрэгжилтийг сайжруулна.	Жилдээ	Сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулна. Дайчилгааны нөөц бүрдүүлнэ. Оюутан цэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	ОНТ	Цэрэг татлагын ажлыг 2 удаа зохион байгуулж цэргийн насны 126 иргэн хамрагдаж цэрэг татлага 72,2%-ийн гүйцэтгэлтэй зохион байгуулсан. Сумын 18-26 насны залуучуудад Цэргийн албаны тухай хуулиар сургалт зохион байгуулж 43 иргэн хамрагдсан. Мөн Цэргийн албаны тухай хууль, Батлан хамгаалах тухай хуулиудаар гарын авлага бэлтгэж 200 гаруй иргэнд тарааж ажилласан. Дайчилгааны төлөвлөгөөний нууцын зэрэглэлийг хангах зорилгоор тусд нь нууц цоожтой цефэнд хадгалж байна. Дайчилгааны нөөцөд 1-р зэргийн үүрэгтний 50 гаруй	100

							иргэнийг хамруулан нөөцийг бүрдүүлээд байна. Цэргийн дүйцүүлэх албыг 6 иргэн мөнгөн төлбөрийн хэлбэрээр хаах болзолыг хангаж уг иргэдийн төлбөр төлөх ажлыг зохион байгуулсан.	
--	--	--	--	--	--	--	--	--

БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

д/д	Зорилт	Арга хэмжээний тоо	Үүнээс				Үнэлэх боломжгүй	Биелэлтийн хувь
			100 биелсэн	Хэрэгжих шатандаа				
				70%	40%	0%		
1.	28	65	49	9	3	-	4	92,6

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

НЗЭЗАХМ

О.БОЛОРМАА

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРГИЙГ

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗДТГ-ЫН ДАРГА

Ж.ЦЭВЭЭНДУЛАМ

Д.ОТГОНЖАРГАЛ